МОНГОЛЧУУДЫН БЭЛЧЭЭР АШИГЛАЛЫН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, БЭЛЧЭЭРИЙН ... ХУУЛИЙН ТӨСӨЛД ХОЛБОГДОХ ЗАРИМ ХИЙСВЭР АСУУДАЛ

/Тойм судалгаа/

Г.Чулуун

Газрын харилцааны эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн багц хуулийн төсөл хэлэлцүүлгийн шатанд явж байгаатай холбогдуулж УИХ-ын гишүүн, сайд Х. Баттулга монгол түмний бэлчээр ашиглаж ирсэн түүх уламжлалын “эрхзүйн [эртний] үндэс” –ийг тодруулсан мэдээлэл бэлтгүүлэхээр УИХ-ын Тамгын газрын Судалгааны албанд хандсан юм.

Малын бэлчээрийг өмчлөх - эзэмших - ашиглах - хамгаалах тал дээр монголын түүхийн сурвалжид нэгдор багцалсан шинжтэй тухайлсан өгүүлэмж бараг таардаггүй. “Орондоо орох завгүй олзлон булааж” явсан баатарлиг явдалт балар тэр цагт бэлчээр нутаг [гэдэг] хамгаалбал зохих [түр зуурын чухаг объект] байсан нь үнэн ч, талын нүүдэлчдийн хувьд бол, хэзээ ч .. тэргүүн зэргийн шийдвэл зохих нэгдүгээр асуудал байгаагүй, нүд салгалгүй манах учиртай үл хөдлөх өмч хөрөнгө байж чадаагүй юм. Харин, сурвалж бичигт бэлчээр нутгийн талаар тэмдэглэгдэж үлдсэн дам өгүүлэмж нилээн байна.

Захиалагчаас ирүүлсэн хүсэлтэд[93], мөн [өнөө цагийн] “бэлчээрийн маргаан”, “бэлчээр ашиглалтын таалаархи гадаадын улс орны эрхзүйн зохицуулалт, туршлага” .. зэргийг тухайлж дурдсан байв. Тиймээс, сэдэв бүрээр лавлагаа тодруулга гаргахыг эрмэлзэж байгаа ч манай боломж зарим талаар хязгаарлагдмал байна. Дурдсан сэдвүүд газрын хуулийн хүрээний .. бэлчээрийн асуудлын ерөнхий агуулгатай ч дор бүрнээ өөр өөр өгүүлэмжтэй, нэг нь нөгөөтэйгээ [төдийлэн] шууд холбогдохооргүй юм. Энэ нь тэдгээрийг зааглан тодорхой хэсгүүдэд хуваан үзэхэд хүргэсэн болно.

Монголд газар өмчлөлийн тухай хууль гараад багагүй хугацаа өнгөрчээ. Гэсэн ч нийслэл .. суурин хот газарт газар өмчилсөн хүний тоо өнөөг хүртэл 300000 –ын босгыг даваагүй байгаа юм. Малын бэлчээрийг малчдад эзэмшүүлэх, өвөлжөөг өмчлүүлэх асуудал шийдвэр гаргах түвшинд энэ хугацаанд хэдэнтээ сөхөгдсөн ч хуульчлагдаагүй. Хөдөөний малчдын зарим нь ядаж өвөлжөөний газраа ч болов өөрийн болгоод авчих сонирхолтой байдаг ч судалгаа тандалтаар бэлчээрийг дундын эзэмшил хэлбэрээр үнэгүй ашиглах уламжлалт арга сонирхол давамгайлсаар иржээ. Малын бэлчээрийг эзэмшиж ашиглаж ирсэн монгол түмний уламжлалт арга ухаан ямар байсан, яаж өөрчлөгдөж “хөгжиж” ирснийг дор бид нэгтгэн тоймлов.

* * *

1. ЭХ СУРВАЛЖИЙН ЭШ БҮХИЙ “БЭЛЧЭЭРИЙН МЭДЭЭ”-НИЙ ТОЙМ

[**Х зуун**] -наас урагш ..
Түмэн шанюйн хүү Модун шанью “улсын үндэс – газар [бэлчээр] мөн, хэмээжээ. Эзэнт гүрнээс өмнөх үеийн язгуурын монгол угсаатнуудыг хятан нараар төлөөлүүж, тэдний газар бэлчээрт хандаж ирсэн үзэл хандлагыг мөчидхөн боловч өнгийе. Киданы үеийн монголчууд **өвс хадлан базаах**, **мал сүрэг адгуулах** .. бүхий л үйлийг эмс хүүхэд рүү түлхэж, тэднээс олон иргэд дор бүрнээ булаах хулгайлахад шамдаж, харгис хатуу авирлаж,

[93]УИХ-ын гишүүн Х.Баттулгын 2013.5.16-ны өдрийн 8/5553 тоот албан бичиг;

ямар ч цаазнаас айлгүйгээр үхэж, [тэд] цөм хулгай худал болсон; тухай сурвалж бичигт өгүүлжээ. Киданчууд X зуунд хүчирхэгжсэн гэх. Хятан нарт газрын харилцааг зохицуулсан хууль дүрэм байсан ба газрыг язгуурын эдэлбэр газар, тариа ногооны, бэлчээрийн, ан гөрөөний, хүүр оршуулгын; гэж ангилж байжүхүй.

1000-аад оны Хятан гүрэн

> Мал их өссөн тул хятан нар “улсын сүргийг эрхлэх [адууны .. г.м.] яам” газар байгуулжээ. Тэгэхээр, мал аж ахуйн [нэг ёсны] удирдах газартай байсан энэ улсад газар-бэлчээрийн эрхзүйн бүдүүлэг боловч зохицуулалт эрхбиш байсан гэдэг эргэлзээгүй болж ирж байна.

[**1189**] оноос өмнө ..
Монголын нууц товчоонд бэлчээр нүүдэлтэй холбоотой өгүүлэмж элбэг. Жишээ нь, МНТ-ны §96, 234-д “нутаг зааж [товлоод, Сэнгүр горхиноос Хэрлэн мөрний Бүрги эрэгт рүү нүүхэд] .. хорчин, торгууд нар ордны баруун зүүн этгээдэд явтугай” гэжээ. Нутаг сонгож нүүнэ гэдэг бол малчин монголчуудын хувьд, угтаа бэлчээр сэлгэх шилжилт юм. Сонгосон газрыг нь өөр этгээд давхар сонгочихсон байвал бөөн аюул болно. Тиймээс их нүүдэл их дэгтэй .. харуул хамгаалалтын дор явагдах ёстой байжүхүй.

Мөн, §118-д Тэмүжин Жамуха хоёр янаг найртай байж, жил хагас хамт суусаар нэг өдөр тэр нутгаас нүүе гэлцэж, зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдрийг сонгов. Тэмүжин Жамуха хоёр, хөсөг тэрэгний урд явж ахуй дор Жамуха өгүүлрүүн, “Тэмүжин анд аа! Ууланд шахан бууя .. адуучинд гэр болтугай. Голд шахан бууя .. хоньчин хургачинд хоол болтугай, гэв. [Хагас нь адууны **бэлчээрийг татаж** ууланд бууя, хагас нь **хонины бэлчээрийг** дагаж голд бууя .. “салъя” гэсэн үг бололтой]. Тэмүжин, Жамухын үгийг үл ухан хариу хэлэлгүй хоцроод арын хөсгийг хүлээж эхээс асуув. Өэлүн эхийг ам нээж амжаагүй байтал, Бөртэ үжин өгүүлрүүн: “Жамуха анд уйдамхай билээ. Биднээс лав уйдаа биз. Бүү бууя. Эндээс .. шулуухан Жамухаас хагацаж шөнө турш явъя” гэвэй.

> Энд “удирдагч нар” хоорондын далд сэтгэлийн дотоод гүн зөрчлөө [байнга гарсаар ирсэн, хэн ч тэгтлээ анзаарамгүй яль шальхан зүйл болгож] “бэлчээрийн талаархий санал зөрөлдөөн” төдийхэнээр харагдуулан халхавчилсан шиг байгаам. Бэлчээр дагасан нүүдэл суудал хээзээнээсээ малчин монгол ахуйн [өдөр тутмын] үндэс суурь байсан нь МНТ –ны агуулгаас харагддаг.

[**1206**]
Чингис хааны “Их засаг” цаазад малын бэлчээрийг онцгойлон үзэж, түүнийг эвдлэн сүйтгэх явдлаас хамгаалахыг чухалчилжээ. Өвс ургамал ногоорсон хойно газар нүхэлсэн, бэлчээр сүйтгэсэн хүнийг шийтгэх, малын бэлчээрийг мянган (засаг захиргааны нэгж) бүрд хуваж “өгч” тэдний эзэмшилд байлгах, гал түймэр алдаж бэлчээр шатаасан хүнийг алах, малын хэвтэр, хашаан дотор шээхийг цээрлэх тухай энэ хуульд заасан байдаг.

Их Юань улсын “Хар татаарын хэргийн товчоон” сударт дээрхтэй төс бүхий өгүүлэмж бий гэх. Ер нь, монголын эзэнт гүрний үед хязгаарын доторхи бүх газар нутгийг эзэн хааны (улсын) өмч хэмээн үзэж байж. Газар шороо, уул ус, нутаг бэлчээр, өвс ургамалаа хайрлан дээдлэж, зөв зохистой ашиглахыг их хаанд “дээрээс” хүлээлгэсэн тэнгэрийн захиас гэж үздэг байв. Ийм учраас тэр талаарх хуулийн заалтууд шашин суртахууны болон зан заншлын шинжийг ихээр агуулдаг байна. Мөн “газар нутаг”, “ус бэлчээр” гэсэн ойлголт нь түүн дээр оршин ахуй айл хунар, ургамал ногоо, нуур ус, ан амьтантайгаа “нэгцул, цуг явж ирсэн” нь нүүдэлч амьдралын онцлогтой холбоотой байсан гэж үзнэ.

Чингис хаан мянган бүртээ газар хуваарилан, түүнийг хэрхэн эзэмших, зохицуулах эрхийг мянгатын ноён [засаг захиргааны нэгжийн удирдлага] - д мэдүүлсэн. МНТ-ны §219-д, Сорхон шар, Хорч зэрэг үнэнч зүтгэж үйл бүтээсэн эрх бүхий ноёдод газар нутаг, өрх иргэнийг зарлигаар эзэмшүүлжээ.

[**1337**]
Хубилай сэцэн хааны үед монголчууд өмнөд хятадыг эзэлснээр тариа будааг тэндээс саадгүй зөөх болж, ар нутагт тариалан эрхлэх нь багассаар 1337 онд Тогоонтөмөр хааны зарлиг гарч, монгол нутаг зөвхөн малын бэлчээрт зориулагдах болсон гэдэг.

[**1574**]
Түмдийн “Алтан хааны цаазын бичиг” ард олны чухаг баялаг болох мал сүргийг хулгайн аргаар хөөж **бэлчээрийг солих**, муу санааны үүднээс гал түймэр тавих зэрэгт хариуцлага хүлээлгэх тухай заалттай юм.

> “Малын бэлчээрийг солих” гэсэн нэг ойлголт энд гарч байна. Мал сүрэг дассан бэлчээрээсээ хэт холд хөндийрвөл [тэр жилдээ] таргалдаггүй. Тарга тэвээрэггүй мал хариг цагийг давахгүй. Зөвхөн бэлчээрийг хямгатай ашиглаад зогсохгүй, [тэндэхийн] малыг идээшсэн бэлчээрт нь адгуулахыг чухалчилдаг байж.

[**1600**]
“Халхын үйсэн дээр бичсэн цааз эрхэмжийн бичиг” -т мод хатгасан газар мэдэж байж бууваас гурван ест буй, эс мэдэж бууваас нэгэн морь ав; гэсэн нь тухайн үедээ газар бэлчээр эзэмших ашиглах харилцааны өвөрмөц нэг зохицуулалт байв.

> Энд нэг анхаарууштай зүйл байна. Хэн эрх дархтай хөрөнгө чинээтэй нь эхэлж очоод “хожим (нүүж) буух газраа мод хатгаж тэмдэг тавьдаг” байж. Зэлүүд газарт хаана хэн “гадас шаасныг” хэн хүн тэр бүр мэдэх бололцоогүй. Гэтэл, шав тавьсаныг мэдэлгүйгээр ирээд буусан ч гэсэн уг “айл” шийтгэлээс мултарч чадахааргүй хуультай байсан байна. Эрхтэн дархтан эхэлж буудаг, эрх мэдэлгүй хөрөнгө чинээгүй нь тэднээс “шав тавьсан эсэхийг асуухыг албадсан шахуу” .. хүнийг нийгмийн байдалаар нь эрэмбэлсэн [тийм] заалт зохи-цуулалт юм.

[**1626**] оноос хойш ..
Энэ үе хангалттай хугацаа эзэлнэ. Түүх бичигт 1691-1911 оныг үүнд хамаатуулдаг ч монголын зарим хэсэг манжийг дагасан нь үүнээс хавьгүй эрт билээ. 1610 -аад он хавилцаа өвөр-монголын харчин, хорчин, жаруд аймаг манжуудтай ургийн холбоо тогтоон .. тэндээс шан харамж авч .. холбогдсон байдаг. Манжийн үед монголын Улиастайн жанжны газраас захирч, ингэхдээ монгол түмэн “Манж чин улсын бүгд хууль, Халх журам, Гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг (Монгол цаазын бичиг)” –ийг дагаж байв. Манжийн хаанаас “шинэ дагасан [халх нарыг тэдний хууль ёсоор] болтугай” хэмээн зарлиг буулгаж байсан нь тэдний “захиран засах арга ухаан” нилээн уян хатан байсныг харуулна.

Манжууд монголчуудын бэлчээрийг хамгаалах, ялангуяа түймрийн эсрэг тэмцэхдээ хэрэглэж байсан уламжлалт хууль ёсыг говийн умард нутагт 300 шахам жилд төдийлэн хөндөөгүй байдаг. Гал түймэр алдаж ой бэлчээр устгаж үлэмж гэмтээсэн, [энэ ялдар] хүний амь хохироо-сон, бусдад их хэмжээний уршиг тарьсан тохиолдолд хэрэглэх шийтгэл Монгол цаазын бичигт “бараг хуучнаараа туссан” юм. Жишээлбэл,

- Нүх утахад (ан авын үеэр гэсэн утгатай болов уу) түймэр алдвал хэн мэдсэн хүн нэгэн есөн мал авагтун. Ихэд унтраад мал үхвэл төлүүлэгтүн. Хүн үхвэл гурван есөн мал авагтун. Зүгээр эндэж түймэр алдвал мэдсэн хүн таван мал авагтугай. Түймэр унтраад мал үхвэл төлүүлж авагтун. Хүн үхвэл төлөө нь нэгэн есийг авагтун; гэжээ.
    - Энд, “нүх утахад” .. мөн, “зүгээр эндэж” гэх мэтээр гэм буруугийн “болгоомжгүй хэлбэр”-ийг хүртэл зааж өгчээ. Мөн, түймрийн улмаас учирсан хор уршгийн зэргийг “тогтоож”, хүлээх харуцлагыг тодорхойлсон гэж үзнэ.

Түймэр - бэлчээр сүйтгэлийн шалтгаан болой. Уг гэмт үйлдлийн улмаас бэлчээр сүйтгэгдээд зогсохгүй .. [тэр зуурт] мал үхвэл түүнийг бүрэн хэмжээгээр төлүүлдэг байжүхүй. Түймэр алдсан этгээдийг илрүүлэхэд гэрчийн мэдүүлэг чухалтай. Тиймээс, түймрийн гэрчийг урамшуулах хэлбэрийг ч авч үзсэн байдаг аж.

[**1709**]
Гурван хушууны их цааз буюу “Халх журам”-д газар эзэмшил, бэлчээр хамгаалах, газар нутгийг онголон дархлах тухай хэм хэмжээг тогтоожээ. Бусдын өвсийг мэдэж байж малд идүүлэн сүйтгэх (энэ нь, авсан хадлангийн тухай буюу “бэлэн өвсний” талаарх үг заалт байж магадгүй юм), тарианд мал оруулж сүйтгэл тарихыг хориглох, түймэр шатваас зартай заргүй ирж унтраах тухай заажээ. 1700 -аад оны эхээр манжийн цэрэг монголд ихээр байршиж, цэргийн хэрэглээний зориулалтаар ялангуяа сэлэнгэ тийшээгээ тариа ногоо тарих ажил [нэг хэсэг] эрчимжсэн байдаг юм.

Дээрх Их цаазаар Хан-Уул, Төхөм, Шивэрт, Онгон, Зоргол, Адаацаг, Улааннуур зэрэг 10 гаруй газрыг онголжээ. Богд уулын ар дахь Их тэнгэрийн ам эртний Монголчуудын тэнгэр шүтэх тахилгын газар байв. Бүр XIII зууны үед Хэрэйд аймгийн Ван хан Богд уулыг анх тахиж, Хан уул гэж нэрлэн түүний хөрс шороо, ой мод, цэцэг жимс, ан гөрөөс, жигүүртэн шувууг үе улируулан хамгаалах үндэс суурийг тавьжээ.

> Үржил шимт нутаг орныг .. бэлчээр сайт нөмөр нөөлөг газар усыг хүчлэн хамгаалж ирсэн монголчуудын энэ туршлага тэдгээрийг “хамгаалахын тулд” хамгаалаагүй .. хатуу хариг цаг ирэхэд “үүц” - нөөц бэлчээр байлгах санаа сэдэл бүхий байсан гэдэг. Тэр үед хөрс хүүлэх, байгаль дэлхий сүйтгэх оньсон техник гараагүй, хүн зон цөөн, дээр доргүй бүгд малчин байв. Ямаагаа хариулаад яваад байдаг [ер олдоггүй] засаг ноён

ч байсан байгаам. Монголын нийт хүн ам XX зууны эхээр [дөнгөж] 0. 5 сая хүрэхтэй үгүйтэй байж.

[**1778**]
Богдхан уулыг дархан цаазтай газар мөн гэж батламжилж, хууль зүйн статустай болгосон нь дэлхийн түүхнээ “байгаль хамгаалсан” анхдагч жишээний тоонд ордог. Хэнтий хан уулыг арай хожуу дархалжээ.

[**1795**]
"Монгол цаазын бичиг” (МЦБ) -ээр газар ба бэлчээрийн асуудлыг зохицуулахдаа тогтоосон засаг захиргааны нэгжийн хуваарийг зөрчих, мөн өөрийн харьяалагдах засаг захиргааны нэг-жээс дур мэдэн гарч нутаглахыг шууд хориглож байв. Тухайлбал,

- Өөрийн хуваасан нутагт засаг ба засаг бус вангууд орвол арван адуу, бэйл, бэйс, гүн бол 7 адуу, тайж, тавнан бол 5 адуу, харц хүн бол өрх тоолон тус бүрээс 1 үхэр ав. [94] Мөн, “хуваасан жасааны нутгийн захаас гарч тусгаар **нүүж нутаглаваас** засаг ба засаг бус ван, бэйл, бэйс, гүн, тайж, тавнан бол нижгээд [1] жилийн пүнлүү тасал. Пүнлүүгүй тайж, тавнан бол 50 адуу ав. Харц хүн бол үзсэн хүн түүний бие хийгээд гэр, мал сэлт бүгдийг автугай[95] .. гэх мэт.

  Дээрх цаазын зохицуулалт тухайн үед газар, бэлчээр түүнийг эзэмших хамгаалахтай холбогдсон зөрчил маргаан түгээмэл байсныг харуулна. Нөгөө талаар газар бэлчээр эзэмших журам зөрчсөн этгээдэд хүлээлгэж байсан хариуцлага хэлбэрийн хувьд [нилээн] хүнд шийтгэлд орно. 50 адуугаар торгох, харцыг боол болгох зэрэг ял нь бусад төрлийн гэмт хэрэгт ногдуулж байгаа ялтай харьцуулбал ихээхэн хүнд шийтгэлийн төрөлд хамаарахаар байдаг.

[**XIX зууны дунд үе**] хүртэл

Энэ үеийн манжийн төрийн бодлого монголчуудыг уламжлалт аж төрөх байдлаар нь байлгаж, хэрэгтэй цагт ашиглах, түшиг тулгуур болгох, холбоотон байлгах зорилго бүхий байж. Ингэхдээ тэд монгол нутгийг хошуу, чуулганы зохион байгуулалтанд оруулжээ. Манжийн засгийн зүгээс монголд явуулсан бодлого хандлага энэ үедээ харьцангуй зөөлөн байсан ба монгол нутагт уурхай нээх, газар сэндлэхийг хориглож, худалдааны хятад иргэдийг зөвхөн тодорхой хугацаа-гаар [монголд] орохыг зөвшөөрч байв;

[**XX зууны эхэн**] хүртэл

Манжууд хятадад уусч, манжийн хааны ордон дахь хятад түшмэлийн тоо олшрохын хэрээр [тэдний зүгээс монголын талаар баримтлах] засгийн бодлого нь аажмаар хятадын бодлого болон хувирсаар байв. Энэ үед монголын талаарх өмнөх абзацад дурдсан “зөөлөн бодлого” алга болсон юм. Ингэж Чин гүрний шинэ засгийн бодлого эхэлж .. халх монголын нийгмийн байдал хүндэрсэн.

Хятадууд монголчуудын **малын бэлчээрийн зарим хэсгийг хурааж,** [бас] **худалдан авч**, нутгийн гүнээс газаргүй ядуу олон мянган иргэнийг зохион байгуулалттайгаар ар газраа суулгаж, тэдний амьдралыг өөд татахыг эрмэлзэв. Хятад төрийн шинэ засгийн хахир бодлого монгол газар ийн хэрэгжсэнээр .. монгол түмэн зовлон гамшиг амсаж, өрөнд баригдаж, .. улмаар тусгаар тогтнолынхоо төлөө босч тэмцсээр төр улсаа дахин сэргээж авсан түүхтэй.

[94]Монгол цаазын бичиг, V дэвтэр, 1-р зүйл;
[95]Мөн тэнд;

> Дашрамд тэмдэглэхэд, хятад хүнийг монгол хүнээс ялгамжлахын тулд “иргэн” гэдэг байж. Думдад иргэн улс гэдэгтэй ч мэдээж холбогдоно.

Сэдвийн хүрээндээ асуудлыг тухайлан лавшруулбаас, бэлчээрээр нь оролдвол монголчууд хээзэнээсээ босдог тэмцдэг байсан төлөв байдал ажиглагддаг юм. Дээхнэ үедээ ч тийм байж, одоо ч байдал мөн хэвээр буюу. Жишээ нь,

- Өвөрмонголд, өнөө цагийн монгол малчид бэлчээрээ хашаагаар тойруулж хашч .. эзэмшдэг. 2010.5.10 –нд Шилийн гол аймгийн Баруун үзэмчин хошууны нэг малчныг эзэмшсэн бэлчээртээ машин оруулахгүй гэж эсэргүүцэнгүүт нь тэндэхийн нүүрсний уурхайн жолооч нар машинаараа дайрч хөнөөжээ. Хохирогч хэсэг нөхдийн хамт бэлчээрээ хамгаалан нүүрсний тээврийн замыг хаасан байдаг. Хэрэг явдал .. нутгийн монгол иргэдийн дургүйцлийг хүргэснээр өвөрмонголын олон газар эсэргүүцэл хөдөлгөөн өрнөв. Оюутан голцуу олон мянган хүний жагсаалыг цагдаагийн хүчээр тарааж, 90 гаруй жагсагчийг баривчлан, 40 хүнийг барьж хорьсон талаар Dailynews мэдээлж байлаа. БНХАУ –ын Засгийн газар олон нийтийн эсэргүүцлийг анхаарч .. хүн дайрсан хятад жолоочид цаазын ял, түүний сэлгээ (смена) жолоочид бүх насаар нь хорих ял оноож, хохирогчийн ар гэрт нөхөн олговороор 560000 юань (86000 ам. долл.) өгсөн гэх ба ус бэлчээрээ хамгаалан тэмцсэн монголчуудын шаардлагад .. дурарараан загнаж байгаа нүүрсний компаниудад хатуу арга хэмжээ арга хэмжээ авна; гэж мэдэгджээ.

[**1911**]
Богд хаант Монголын улсын үед, одоогийнхоор бол, хөдөө аж ахуйн газрын улсын нэгдсэн тооллого болж, .. газар тариаланд тохиромжтой 512400 га. газар байгааг тогтоон, Түшээт хан аймгийн Хараа, Засагт хан аймгийн (Ховдын) Буянт зэрэг газар “сангийн тариа” нэртэй улсын аж ахуй байгуулж, аймгуудын ноёдод тариаланг хөгжүүлэх зарлиг хүргүүлсэн байдаг ч, орон нутагт тэр зарлигийг хайхралгүй .. харин ч бүр тариалангийн талбайг багасган, үүнийгээ **малын бэлчээрийг хамгаалах** нэрээр зөвтгөн тайлбарлаж байв. Улмаар Богдын засгийн газар 1919 онд “бүтээгүй тэр” шийдвэрээ арга буюу хүчингүй болгожээ.

[**1918**]
Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичигт, ИхБогд, ХанХэнтий уулын **тэнгэрийг** жил бүр зун намар хоёр цагт, Отгонтэнгэр уулын тэнгэрийг зуны дэлгэр цагт 1 удаа тахиж байхыг заасан байна. Богд хаант Монгол улсын үед Богд ууланд харуул цагдаа нарыг суулгаж, хэрэглээний (албаны) уналга хөсөг өгч байв.

Газар, бэлчээрийг эзэмших, ашиглах талаар **нутаг ус, өвөлжөө бууцаа миний, чиний хэмээн булаалдах зарга маргаан үе дамжин маш ихээр гарч байсан** бөгөөд түүнийг харьяат хушуу ноёд ихэвчлэн түүгээрээ шийдвэрлэн зохицуулдаг байжээ.

> Дашрамд тэмдэглэхэд, ус бэлчээр арвин, ургац гарцыг тэгш дүүрэн байлгах гэж монголчууд “тэнгэр тайх эртний ёс” –ыг уулан дээр гарч “тэнгэртээн илүү ойртож байгаад” үйлддэг байжээ. Уул овоог биш .. уулын тэнгэрийг тахидаг байж. Сурвалжид, бичлэг нь хүртэл “уулын тэнгэрийг тайх” гэдгээрээ явж бий. Харин, уул усыг онголон дархлах нь тайхилга сүлднээс өөр .. ёстой жинхэнэ бэлчээр ус нөөцлөх - аривтгах чиглэлийн “бодит ажил” байсан гэж үзмээр юмуу.

[**1921**]
Энэ үеийн [ардын] засгийн бодлогын нэг хэсэг нь газрын харилцааны эрхзүйн зохицуулалтыг өөрчлөн шинэчлэхэд чиглэж байв. Үүнд холбогдох гол баримт бичиг бол 1921.5.21 -ний өдөр гаргасан Түр засгийн газрын XIX хурлын тогтоол юм. Энэ тогтоолд, Монгол Улсын

бүх газар шороог үүнээс хойш гадаад дотоодын хүн нар миний хэмээн түрэмгийлэн эзлэхийг үүрд зогсоовой; хэмээжүхүй. Энэ нь, газрыг улсын өмч, ард нийтийн хүртээл болохыг анх удаа хуульчилсан улс төр, нийгэм, эдийн засаг, хууль зүйн ач холбогдолтой, тухайлсан заалтынхаа хувьд үндсэн хуулийн шинжтэй, чухал баримт бичиг юм.

[**1924**]
Анхдугаар конституцид “БНМАУ -ын хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ой мод, ус, тэдгээрийн баялгууд нь ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно” гэсэн. Үндсэн хуульд бас “Газар эдлэх нийтийн дүрмийг батлах, аймаг, хушуудын нутгийн хил хязгаарыг байгуулах, дэлхийн баялгийг ашиглах дүрэм заавар тогтоох”-ыг Улсын дээд эрхийг хадгалах газрууд эрхлэн шийтгэвэл зохимой” хэмээсэн байна.

[**1926**]
Үндсэн хуулийн [дээрх] заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас олон шийдвэр гаргасны нэг нь “**Газар бэлчээрийг эдлэх тухай**” 227 дугаар тогтоол юм. Тогтоолд,

- Ард олны дотор бие биесийг нутаг бэлчээр, өвөлжөө бууц зэргээр гачигдуулан хохироож, маргаан будлиан үүсгэн, илүү нутаг эзэрхэх явдал гарч байгааг зогсоох, гагцхүү олон онд нутаглаж, хүн мал идээшсэн, хөрөнгө малын олон цөөний байдалд тохируулан аль бололцоод бууц бэлчээрийг нутгийн эрх баригчдаас зүй зохисоор заан олгуулж байх; гэж заажээ.

> Ардын засгийн он жилүүдэд ч монгол газарт монгол малчид өвөлжөө бууцаа газар бэлчээрээ булаалдаж нэг нь нөгөөгөөс илүүг эзэмшихээр тэмцэлдсээр байсныг эндээс бэлээхэн харж болж байна.

[**1928**]
Засгийн тогтоолоор “Монголчууд тус улсын хязгаарын дотор **нутаг бэлчээрийг эдлэх түр дүрэм**”-ийг баталж .. олон ардууд эрх биш өөр өөрийн нутгийн хязгаар дотор нутаглавал зохих, шалтгаангүйгээр бусад хушууны нутагт нүүдэллэн орохыг хязгаарлах, хэрэв хил тодорхойгүй бол түүнийг шинэчлэн тогтоох, ган зуд тохиолдох үед өөр өөрсдийн захиргааны байгууллагаар уламжлан урдаас зөвшөөрүүлж байх” -ыг тогтоосон юм.

[**1935**]
Улсын бага хурлын тэргүүлэгчид, Сайд нарын зөвлөл 1935. 8. 25 -ны дотор “Бэлчээр усыг эдлэх дүрэм” баталж, тус улсын харьяат нар, улсын ба хоршоо аж үйлдвэр, олон нийтийн байгуул-лагууд бэлчээр усыг үнэ төлбөргүй, хугацаагүй эдлэх бөгөөд гадаадын харьяат нарт түрээсээр эдлүүлэх тухай заажээ. Газрын харилцааг зохицуулахад “Газар шороог хэрхэн эдлэх тухай дүрэм”, “Хадлан хадах, тариалан ногоо тарих тухай хууль” чухал ач холбогдолтой байв.

[**1942**]
Газар эдэлбэрийн тухай хууль нь бүх иргэд, тэдний үйлдвэрийн нэгдэл ба хоршоо, үйлдвэр зэрэг улсын байгууллагад газар шороог бэлчээр өвс, хадлан тариаланд ямар ч үнэ төлбөргүй, хугацаагүйгээр ашиглуулах зорилготой гарчээ. Уг хуульд, газар эдэлбэрийн эрхийг:

1) Хувийн аж ахуйтнуудын хөдөлмөрийн газар эдэлбэрийн эрх;
2) Артель ба олон нийтийн газар эдэлбэрийн эрх;
3) Улсын аж ахуйтан ба станц, аж үйлдвэр, албан байгууллагын газар эдэлбэрийн эрх гэж тус тус зааглан ангилжээ.

[**1960**]
БНМАУ-ын [гуравдахь] Үндсэн хуульд өмнөхөөсөө ялгаатай нь, “хөдөө аж ахуйн газрын газрыг [эзэмшигчид нь] үнэ төлбөргүй, байнга эдлүүлнэ” гэсэн хэм хэмжээ нэмж оруулсан явдал юм.

[**1971**]
“БНМАУ-ын газар эдэлбэрийн хууль” гарч, түүгээр газрын харилцааг тусгайлан зохицуулсан бөгөөд газрын нэгдсэн санг эдэлбэрийн зориулалтаар нь,

1. Хөдөө аж ахуйн эдэлбэр газар;
2. Хот, суурины эдэлбэр газар;
3. Тусгай хэрэгцээний эдэлбэр газар;
4. Ойн фондын газар;
5. Усны фондын газар;
6. Улсын нөөц газар; гэсэн [тухайн үедээ шинэ тувтам] ангиллыг бий болгосон юм.

Энэ хуульд газар эзэмшигчид, тэдний эрх, үүрэг, газар олгох, авах журам, газрын бүртгэл, тоо бүртгэл, хяналт, газар зохион байгуулалт, газрын маргааныг шийдвэрлэх, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тухай тодорхой заажээ. Хуулийн хэрэгжүүлэлтийн хүрээнд хөдөө аж ахуйн үлгэрчилсэн дүрэм (1974) батлагдсан байдаг. Тэр үед бэлчээрийн бэрхшээл харьцангуй бага, монголын малын тоо толгой 25 саяаас хэтрээгүй буюу “байдал өнөөгийнхөөс сайн нөхцөлтэй” байсан гэж үзнэ.

* * *

2. **“БЭЛЧЭЭРИЙН ЗОХИЦУУЛАЛТ”** [ӨНӨӨГИЙН] **ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ОРЧИНД**

1) **Монгол Улсын Үндсэн хууль** [1992] **-д** ... [96]

Газрын харилцааны .. түүний дотор бэлчээрийн тухай асуудлыг монголд 1992 оны конституцийн агуулгад “зааснаар” хуульчлан зохицуулж явж ирэв. Тиймээс, энд Монгол Улсын Үндсэн хуулийн “бэлчээрийн асуудал” –тай шууд ба дамаар холбогдох заалтуудыг түүж харангаа, завсарт нь зарим талын “эргэцүүлэлт тэмдэглэл” хийе. Монгол Улсын Үндсэн хууль (1992) –д зааснаар,

Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна; Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна; Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн; Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэг-цээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй;

> Бэлчээрийг өмчлүүлж болохгүй; гэсэн Үндсэн хуулийн энэ заалт социализмын үеийн нэгдлийн дарга нарын зонхилсон хурлаас гарсан тийм шийдвэр юм. Тухайн цаг үеийн засаг захиргааны нэгжийн дарга нар бол “мал-малчин-бэлчээр хадлан”-гийн асуудал дээр “улсын хэмжээний, салбарын гаршууд мэргэжилтнүүд” байсныг тэмдэглэн хэлэх нь зөв болов уу Тэд (тэдний баг) туршлагаараа, зөнгөөрөө “бэлчээрийг

[96]Ардчилсан хувьсгалын дүнд бий болсон Үндсэн хуулийн “шинэ” гэсэн тодотголтой явсан үе хугацааны эрхээр улирч, 1992 оны конституц эдүгээ нилээн хуучирчээ. Тиймээс, нийтлэгээр хэрэглэж ирсэн “шинэ” хэмээх тодотголыг энд бид зориуд хэрэглэсэнгүй.

> өмчлүүлж болохгүй” гэдгийг мэдсэн шиг байгаам. Уг нь, бэлчээр бол газар, газрыг бол өмчилж болдог, тиймээс бэлчээрийг ч мөн өмчилж болох учиртайсан. Яагаад тэд үүнд эрс бөгөөд итгэл төгс “үгүй” гэж хэлэв. Ихээхэн бодох ёстой “тэднийг дахин сонсох” газар бол чухамдаа энэ юм.
>
> Харин тэд нэг зүйлийн урьчилан зөв төсөөлөөгүй байж болох талтай. (Бид хийсвэр талдаа зүйл ярина гэдгээ гарчигтаа эхлээд илэрхийлсэн) Улс орны хөгжил дэвшил урт хугацааны үйл явц. Үйлдвэржилт, уурхайжилт өндөр эрчимтэй өсөн нэмэгдэх тусам хөдөө аж ахуйн, ялангуяа мал аж ахуйн салбараас олж байгаа орлого ашиг үйлдвэрлэл эрхэлснээс олдож байгаагаас хавьгүй доогуур болж буурна. Ийм байхад хүмүүсийн (залуусын) мал дагах сонирхол үргэж багасах бөгөөд тэгсээр ирсэн нэг тийм зүй тогтол маягийн юм оршин байх бололцоотой. Чухам иймээс мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн сонирхлыг элдэв аргаар хөхиүлэн дэмжих, тэдний гарт “бэлчээрийг нь зоригтой өгөх” санал санаачлага үүсдэг аж. Бэлчээрийг түрээслэх явдал үүнд шууд хамаатна. “Нэгдлийн дарга” нар, тэгэхээр асуудлыг, тухайн тохиолдолдоо зөв, ерөнхий тохиолдолдоо “зөв бус өнцгөөс” харсан байж магад; гэж үзэв.
>
> Бэлчээрийн асуудал дээр Монгол улсын Үндсэн хуулийн заалтыг үгүйсгэн өөрчлөх амаргүй биз ээ. Мөн, түүхэн уламжлал талаасаа ч “өмчлүүлж боломгүй харагдаж байгаа” нь эртэн үедээ монголчууд нэгдүгээрт бүгд малчин байсан, хоёрдугаарт, цөөхүүлээ байсан, тэр чинээгээр дураараа нүүж суудаш “жинхэнэ язгуурын нүүдэлчид” явсантай холбоотой.
>
> Өөр нэг аргумент бол “энэ цагийн .. соц. үеийн ба өнөөдрийн монгол малчид бол хагас нүүдэлч, хагас суурин амьдралтай болж өөрчлөгчихөөд байгааг шийдвэр гаргах дээд төвшиндөө албан ёсоор хүлээн зөвшөөрмөөр байна. Ингэхгүйгээр бэлчээрийн асуудлыг зарчмын хувьд “одоогийнхоос илүү сайн” шийдэх боломж хязгаарлагдмал хэвээр байх биз ээ.

Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно;

> Бэлчээр бол газар мөн. Газрыг өмчилж .. өмчлүүлж болдог. Тэгэхээр бэлчээрийг ч мөн тэгж болох учиртай гэдгийг өмнө тэмдэглэсэн. “Тэгүүлэхгүй” байгаа нь конститцийн агуулгын “дотоод зөрчлийн” илэрц байж мэднэ. Бид, бэлчээрийг заавал өмчлүүлэх ёстой гэсэнгүй. Харин, бэлчээрийг өмчлүүлэхгүй байгаа болзол нөхцөл нь асуудлыг шууд тас цохисон шинжтэй, далд “сонин” байгааг зориуд тэмдэглэж байгаа юм.
>
> Үндсэн хуулийн энэ заалтаар бол монгол малчны “эзэмшиж өмчилж чадахгүй шахуу” байгаа тэр газар - бэлчээрийг “хаанахын ч биш .. харъяалалгүй хүн” гарч ирээд, журмын дагуу мөнгө төлөөд, жишээ нь, бүтэн жилээр ч юм уу [бэлчээрээр] ашиглаад явчих эрх нээгдсэн мэт. Уул уурхайн лицензтэй газраа бэлчээрээр ашиглах тохиолдол ч гарч болно. Үүнийг газрын тухай хуулиар хаахыг оролдсон ч тэр нь хангалттай биш байгаа юм.

Монгол Улсад [хүнийг] нийгмийн гарал, байдал, эрхэлсэн ажил .. -аар ялгаварлан гадуурхаж үл болно. Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

- байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;
- ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох .. хувийн аж ахуй эрхлэх эрхтэй;
- улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох .. эрхтэй;

Малч хүн бол малчны мэргэжлийг [түүгээрээ чөлөөтэй] сонгосон иргэн, бас [их төлөв] хувийн аж ахуйтан байдаг. Сүүлийн үед малчинд мэргэжлийн үнэмлэх хүртэл олгодог болж ирж байна. Иргэн хүн улс дотроо чөлөөтэй зорчдог ч .. малч мэргэжилтэй иргэн болохоороо сум дотроо ч чөлөөтэй нүүх эрхгүй мэт байдалд байсаар. Нүүх ба зорчих ялгаатай. Үүнийг үл үгүйсгэн өгүүлэхэд, иргэн хүн байнга оршин суух газраа [улс дотроо] өөрөө мэдэн сонгож болдог байхад .. малч хүний байнга өвөлжих тэр газар нь баталгаажин албажиж өгөлгүй өчнөөн удав. Малчин хүн **эзэмшсэн мэргэжлээсээ** болоод ийм байдалд ороод байна.

Уг нь хүнийг эрхэлсэн ажлаар нь ялгаварлан хандаж болохгүйг конституц бас хэлсэн. Товчдоо, малчин хүнд бэлчээрийг нь бол “ямар нэг байдлаар” өгөх ёстой мэт. Дашрамд, дахин тэмдэглэхэд, малчдын тухайд бол бэлчээрийг эзэмших ба бэлчээрийг өмчлөх нь [олон талаар, хэзээнээсээ] нэг зүйл байсан, одоо ч бараг тэр хэвээрээ байгаа гэж хэлж болно. Монголчуудын бэлчээр ашиглаж ирсэн түүхэн уламжлал өөрөө ийм ажгуу.

Байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт [нэг] үүрэг мөн.

Бэлчээрээ хамгаалах нь малчин бүрийн журамт үүрэг юм. Бэлчээрээ хамгаалах сэдлээр уул уурхайн компанийн хамгаалагчтай нартай “эрэлхэгээр тулалдаж” байгаа тэр малчид “иргэний журамт үүргээ биелүүлсэн” байж таарахаар байна. Гэтэл, амьдрал дээр малчид их төлөв буруутдаг, хохирдог. Амь насаа алдсан явдал ч гарч байжээ. Иргэний журамт үүрэг гэж нэг биелүүлсэн эзэндээ халтай зүйл байдаг мэт ойлголт төрөх гээд байна, бэлчээрийн энэ асуудлаар жишээлэх юм бол .. .

Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- салбарын ба салбар хоорондын, бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх;
- хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах;

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно; Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ; Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн;

Засаг захиргааны нэгжид хуулиар тусгайлан олгох тэрхүү чиг үүрэг дотор нь “бэлчээрийн асуудлаа түүгээрээ мэдэн” зохицуулах явдлыг оруулж өгөх нь зөв юм. Манай түүх уламжлалын олон жишээ үүнийг “дэмжихээр” байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална; Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ; Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэнэ;

> Бэлчээрийн асуудал бол [засаг захиргааны тухайн нэгжийн хувьд] анхаарахгүй байхын аргагүй, нийгмийн амьдралын чухал асуудал байдаг. Энэ үндэслэлээр орон нутаг бэлчээрийн асуудлыг түүгээрээ өөрөө шийдэх .. орон нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудал байх бололцоотой нь харагдаж байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн аж амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль ба төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн [өөрөө] бие даан шийдвэрлэж болно.

> Бэлчээрийн асуудлыг улс даяар нэг жороор хууль гарган зохицуулах бэрхшээлтэй. Учир нь газар орон бүрт байгалийн онцлогоосоо хамааraад бэлчээрийн зохицуулалт өөр өөр байх шаардлагатай болдог. Бэлчээрийн асуудал [үнэхээр] орон нутгийн асуудал мөн үү биш үү гэдэг дээр нилээн бодож тогтож сайн ярилцах ёстой болов уу.

Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим [манай тохиолдолд, бэлчээрийн] асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад [өөрийнхөө бүрэн эрхээс, эргүүлж авах эрхтэйгээр хасан] шилжүүлж болно.

> Үндсэн хуулийн энэ заалтын дагуу, хууль тогтоох байгууллага өөрийн бүрэн эрхэд хамаарах бэлчээрийн зохицуулалтын асуудлыг орон нутгийн Хуралд албан ёсоор шилжүүлэх нь зүйтэй юм. Бэлчээрийг алсаас хатуу хуульчлах зөв биш алхам байж мэднэ.
>
> - Өнөөдрийн байдлаар, монголд “юун бэлчээр өмчлөх” .. түүнийг малчиддаа “яажшуухан эзэмшүүлэх талаар” ч арга ухаанаа сайн ололгүй явсаар ирлээ. Үүнийг “бүх юм болохгүй байгаа” мэтээр ойлгож гуйвуулмгүйг хэлэх ёстой юм. Монголын мал сүрэг сүүлийн жилүүдэд өссөөр ирсэн нь өөрөө эерэг сайхан үзүүлэлт мөн. Малын абсолют тоо сүүлийн жилүүдэд хэлбэрэлтгүй өссөөр байгаа нь өөрөө “байдал муугүй” байгаагийн дам нотолгоо болно. Асуудлыг олон талаас нь хармаар байна.
>
> - Заримдаа хууль тогтоомж өөрөө нийгмийн хөгжлийн саатуулагч хүчин зүйл болох нь ч бий. Үндсэн хуулийн “тавьсан хориг хязгаарыг” давах гэж нутгийн удирдлагууд их зовдог аж. “Малчдын нөхөрлөл” гэх маягийн зохиомол бүтэц хүртэл бий болгоод, түүндээ “бэлчээрийг эзэмшүүлэх” –ийг оролдоно. Хүн гэдэг .. сайн нь сайнтайгаа муу нь муутайгаа, бас баян хоосноороо ялгаран нөхөрлөх тун дуртай амьтан. Шинэ цагийн малчдын нөхөрлөл “хүний заяамал энэ чанарыг” үл огоорсон албадмал шинжтэй тул нийгмийн сул дорой хэсэгт, ялангуяа сэтгэлзүйн талаасаа, хүндээр тусах бололцоотой.

- Малчдын нөхөрлөл нь Иргэний хуульд заасан “бүртгэгдээгүй холбоо” юм. Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хэд хэдэн айл, холбоо болон нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ийм байгууллагыг **улсын бүртгэлд бүртгүүлэхгүй, бүтэц зохион байгуулалтаа нөхөрлөлийн гишүүд өөрснөө харилцан тохиролцож** тодорхойлдог. Ийм нөхөрлөл эрх зүйн харилцаанд [ороходоо] бүрэн эрхт төлөөлөгч-гишүүдээрээ дамжин оролцдог.

- Малчдын “тухайн нөхөрлөл” хэн нэгэнд үл таалагдах аваас тэр “өмнө нэгтээ дурдсан жамуха анд шиг” салаад явах эрхтэй. Ядуу хүн, “малгүй малчин” хожмын тэр гүр хаан шиг шийдвэр төгс загнаж чадахгүй. Төрийн үүрэг бол хүнийг хүнээс нь хамгаалах, хараат бус байлгах явдал юм. Хуулиар .. хүнийг хүнээс нь хараат байдалд оруулж болохгүй. Өөрөөр хэлбэл, бэлчээр ашиглах малчдын нөхөрлөл ихээхэн “эргэлзээтэй бүтэц” гэж үзнэ. Малчдын ийм нөхөрлөл тэднийг баян хооскоороо ялгарах чиглэл рүү зориудаар түлхэх .. гэхчилэнгийн олон эрсдлийг дагуулахаар байна.

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурал эрх хэмжээнийхээ дотор тогтоол, Засаг дарга захирамж гаргана. Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх бөгөөд түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөнө; Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын эрх хэмжээ, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

* * *

Үндсэн хууль газрын харилцааг өмнөх үндсэн хуулиадад зааснаас илүү өргөн хүрээнд, шинэлэг байдлаар, тодорхой “сайн” зохицуулсан; гэж олон судлаачид үздэг аж. Өгүүлснээс үзвэл, энэ дүгнэлт ерөнхийдөө худал, .. харин ч манай конституц бэлчээрийн асуудлыг өмнөхүүдийн нэгэн адил “тодорхой бус байдалд” зориуд орхижээ; гэмээр байна. Гэхдээ газрын харилцааны асуудал өргөн хүрээтэй, бэлчээрийн асуудал бол түүний зөвхөн нэг хэсэг юм. Ер нь бэлчээрийн асуудлын эрхзүйн зохицуулалтын таарамжийг [эхлээд] явцуу бага хүрээнд хэд хэдэн газар зэрэгцээ байдлаар “туршлагаар тодорхойлох” оролдлого хийгүүштэй санагдсан. Тийн ахул, энэ тал дээр бид цаг их алджээ, гэмээр.

2) **Бэлчээрийн зохицуулалтад** [дамаар] **хамаатах бусад хууль тогтоомж, зарим үйл явдал**

[**1994**]
“Газрын тухай Монгол Улсын хууль” 1994 онд батлагдаж .. төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан. Мөн онд “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хууль гарсан. Газрын тухай хуулийн Тусгай хэрэгцээний газар гэсэн 16 дугаар зүйлд: “16.1. Монгол Улс тусгай хэрэгцээний газартай байна. Улсын тусгай хэрэгцээний газарт дараахь газар хамаарна:

- 16.1.1. улсын тусгай хамгаалалттай газар;
- 16.1.6. аймаг дундын отрын бэлчээр;
- 16.2. Аймаг, нийслэл, сум энэ хуулийн 16.1.1, 16.1.6, 16.1.7 -д заасан зориулалтаар өөрийн эрх хэмжээнд нийцүүлэн газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч болно” гэж заасан.

[**1995**]

Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд авах арга хэмжээний тухай Засгийн газрын 1995 оны 143 дугаар тогтоол гарав. Мөн,

- “Газар зохион байгуулалтын журам”,
- “Газрын төлөв байдал, чанарын улсын хяналтын баталгаа хийх журам”,
- “Газрын сангийн данс бүртгэл хөтлөх, тайлан гаргах журам”,
- “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах журам”,
- “Гэрчилгээ, гэрээний загвар батлах тухай” .. зэрэг акт ч хамаарна.

Тэр үед батлагдсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль” ч газрын харилцааны зохицуулалтад шууд хамаарна.

[**1997 - 2002**]

Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай (1997), Кадастрын зураглал ба Кадастрын тухай, “Газрын төлбөрийн тухай (2002) хууль батлагдав. “Өнөөгийн нүүдэлчид ба бэлчээрийн газар нутгийн ашиглалт” сэдэвт олон улсын симпозиум Улаанбаатарт (ЮНЕСКО -ийн санхүүжилтээр) болсон. Тэнд, “Бэлчээрийн газар нутгийн шинэчлэл” сэдэвт илтгэл хэлэлцсэн байдаг. "Монгол дахь мал аж ахуй, байгалийн нөөцийн менежмент" олон улсын семинар (Хүнс, хөдөө аж ахуйн яам, Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан, 2001) болов. НҮБ -ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилттэй "Бэлчээрийн мал аж ахуйг тогтвор-той хөгжүүлэх загвар боловсруулж, турших" төсөл (2000 - 2002) тус тус хэрэгжсэн.

[**2003 - 2004**]

Голландын Засгийн газрын дэмжлэгтэйгээр “Бэлчээрийн доройтол ба малчдын ядуурал” сэдэвт судалгааны төсөл хэрэгжсэн. Төслийн дүнг “Зууны мэдээ” сонины 2004 оны №200 дугаарт нийтэлжээ.

[**2003 - 2006**]

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Мал аж ахуйн эрсдэл, бэлчээрийн менежмен-тийн үйл ажиллагаа” дэд төслийн хүрээнд Монгол Улсын 8 аймгийн 143 сумын бэлчээр ашиглалтад иж бүрэн зураглал хийв.

> Бэлчээр ашиглалтын зураглал улсын хэмжээнд хангалттай өргөн хүрээг хамран, сум бүрээр шахуу ийн хийгдчихсэн байхад газрын балансын нийлэмж нариин тодорхой байх бүрэн боломжтой юм

[**2007 - 2012**]

Монголд, бэлчээрийн асуудал ялангуяа сүүлийн жилүүдэд их судлагджээ. Бэлчээрээр “дагнасан” засгийн газрын бус .. иргэний нийгмийн .. эхлэл санаачилгын байгууллагууд олноор байгуулагдаж, эрдэм шинжилгээ, шинжлэл судлалын ажил өрнүүлж, тэд, салбарын яам газар, орон нутгийн удирдлагатай хамтран олон арван төсөл хэрэгжүүлж чамлахааргүй туршлагажсан байна. Бэлчээрийн менежментийн чиглэлээрх тоон мэдээлэл ч хангалтай болж.

> Азийн орнуудаас хамгийн их цөлжсөн 5 улсын нэг нь манайх аж. Судалгаагаар, нийт нутгийн 72.5% нь цөлжилтөд ямар нэг байдлаар өртжээ. Бэлчээрийн газар бас нэг иймэрхүү хэмжээ баримжаатай. Тэгэхээр [шууд] талбарын давхцал үүсээд гараад ирж байгаам. Эндээс, бэлчээрийн хөрсний доройтол .. цөлжилт .. энэ бүхэн цаагуураа нэг зүйл юм биш үү!? гэсэн асуулт гарч ирж байна. Энэ мэтээр тодруулах лавлах юм их байна. Цөлжилттэй тэмцэхэд зориулдаг төсвийн хөрөнгийн хэмжээ сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөв. 2007 онд 600 сая, 2008 онд

нэг тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд нийт 14 аймгийн нутагт 234 төсөл, арга хэмжээг санхүүжүүлжээ.

Нэг хэсэг мэргэжилтэн бэлчээрийн менежментээр ажиллаж байхад .. өөр нэг газар зарим нь зөвхөн худгийн менжментээр дагнаж байх жишээтэй. Уг нь, яаж ч бодсон “ус-бэлчээр” өөрөө 1 зүйл баймаар. Бэлчээр гэдэг ойлголтыг “ус-бэлчээр” болгож тодотгомоор байна.

Монголын бэлчээрийн менежментийн холбооны анхдугаар Их хурал (2010) .. уриалга гаргав.

Уриалга хэдэн бүлэгт багцалсан олон заалттай боловч тэдгээр нь өгүүлэмжийн хувьд ерөнхийдөө Үндсэн хуульд “хүлэгдсэн”, зарчмын шинэтгэлийн дэмжих шинэ санаа багатай юм. Бэлчээр өмчлөл-эзэмшлийн асуудалд Үндсэн хуулийн холбогдох заалтыг эргэж харахгүйгээр ямар ч шинэтгэл хийх боломжгүй санагдсан. Бэлчээрийн шинэтгэ-лийн саатуулагч хүчин зүйлийг ч тодруулах шаардлагатай болжээ.

[**2013**]
Хууль тогтоох байгууллага газрын .. багц хуулийг боловсронгуй болгох чиглэлд ажиллаж, түүн дотор Бэлчээрийн . хуулийн төсөл урьдчилсан хэлэлцүүлгийн шатандаа явж байна. УИХ-ын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооноос Газрын тухай багц хуулийн төсөлтэй холбогдуулан мэргэжлийн байгууллагууд, салбарын мэргэжилтнүүдийг оролцуулсан хурал хэлэлцүүлгийг зохион байгуулсаар байна. Энэ явцад “малчдад өвөл-жөөг өмчлүүлэх, бэлчээрийг эзэмшүүлэх байдлаар төлбөртэйгээр ашиглуулах цаг болсон” тухай үг яриа их гарав. Албан тоогоор .. улсын хэмжээнд өнөөдөр, 160 мянган малчин айл (өрх) бий. Дашрамд тэмдэглэхэд, эрүү, иргэн, засаг захиргааны холбогдолтой бусад хуулиудаар ч газрын харилцааны асуудал дамаар зохицуулагдаж явдаг.

3. **НЭМЭЛТ ЗАРИМ САНАА**

I. Малчин олон монголчууд төр ёсоо дээдэж, засаг хуулиийг биелүүлж, “малдаа захирагдаж, малаа дагаж .. [эцсийн дүндээ] ямагт ялж дийлж” явсан давтагдашгүй бахархалт түүхтэй юм. Жинхэнэ нүүдэлчин явсан язгуурын монголчуудын аж төрөх арга ухааны анхдагч үүсэл сэдэл чухамхүү сүргийн бэлчээр, суух – буух нутаг эзэмшлийн хүрээнээс эхтэй, түүнтэй шууд холбоотой нь манай хроно-тоймоос ерөнхийдөө ил байна.

II. Тал нутгийн эсгий туургатны улс гэрээ засч ирсэн “эзэнт бодлого” -ын нэг гол чиглэл нь газраа, малаа, хүнээн яг таг хуваагаад авчихдаг, тэгээд тэрийгээ угсаа залгамжлан захирах, цааз дэг тогтоох .. явдал байв. Нэгэнт газраа “мэдэлдээ” хуваагаад авчихсан хойно, харъяа нутаг бэлчээртээ язгуурын ноёд түшмэд, мэдээж хэрэг, “эзэн сэтгэлээр” хандаж байв. Эрт үедээ улсын хил хүрээ нааш цааш “хөдөлдөг”, газрын эн их, хүн зон цөөн, нүүдэлчдийн аж байдал байгалаас шууд хараат байсан учраас “эзэн мэдсэн” гэх газраа өвөг дээдэс маань өнөөгийн сонгодог утгаар нь “өмчилж бардаггүй” .. тэгж чаддаггүй байж. Тиймээс, монголын эртний түүхэн болон хууль цаазын сурвалж бичгүүдэд, бэлчээрийн холбогдолтой заалтууд нь ерөнхийдөө “заншлын хэм хэмжээ”-г хол даваагүй гэж хэлж болохоор байна.

Малын бэлчээрийн “цөм асуудал” –ыг заншлын эрхзүйн хүрээнд ийн зохицуулж буюу, монгол хүний ёс жудагт их төлөв даатган, харьцангуй чөлөөтэй, олон зууны туршид ерөнхийдөө “сул зоргоор” явж .. явуулж ирсэн уламжлалт тэр сэтгэлгээний хуучин арга

тавил өнөөдрийн манай нийгэм – эдийн засгийн харилцаанд улам бүр таарахгүй болсоор байгаа ч тэссээр .. оршсоор байна. Үүнд эерэг сөргөөр нөлөөлдөг “хөндлөнгийн” хүчин зүйл олон байна:

1) цөлжилт, усгүйжилт, байгалийн давагдашгүй зарим хүчин зүйлийн нөлөө;
2) газар тариалангийн салбарын түрц, тариан талбайн тэлц;
3) нийгэм дэх байгаль хамгаалах сэтгэхүйн хэрээс хэтэрсэн “хэт харамч” байдал,
4) уул уурхайн салбарын хөгжил, тэлэлт, түрэлт;
5) газар өмчлөл, газрын эдийн засгийн эргэлт, талбайн лицензжилт;
6) сүрэг, малын тоо толгойн өсөлт;
7) хүн зоны өсөлт, нийгэм дэх баян хоосны ялгаа, ядуурал;
8) малч дын ахуйн хүрээнд гарч буй эерэг ба сөрөг зарим өөрчлөлт (жишээ нь, өнөөгийн малчид “бараг нүүдэггүй” хагас суурин амьдралтай болсон);
9) малын хулгай, чоно нохой ... (Жишээ нь, хичнээн ч сайхан өвс ургамал ус бэлчээр байлаа гэсэн, тэнд, малчин айл дурааараа хүслээрээ захалж очоод буучихаж төвддөггүй. Яагаад гэхээр .. захалж буусан тэр айл өөрөө айл саахалтынхаа малыг чононоос хамгаалах нэг ёсны буфер бүс болчихдог талтай. Хээр хангайн бүсэд захын айл заналд өртөмхий байдаг. Тиймээс хөдөөний айлууд ерөнхийдөө нэг дор бөөгнөрөмтгий байдаг аж;
10) засаг захиргааны нэгж дэх өнөөгийн удирдлагын “аргаа барсан”, хуулиас хэт хараат (эрт дээр үедээ ийм байгаагүй) байдал, бас .. захиргаадалт;
11) бусад (малчдын хамаатанжсан байдал, үлийн цагаан оготно .. г. м.);

III. Олон судлаач мэргэжилтнүүд, монголд, газрыг албан ёсоор өмчлөх болсон, энэ цагийг хүртэл **малын бэлчээр монголд хэзээ ч өмчлөлийн зүйл болж байгаагүй**, харин, бэлчээрийг эзэм-ших, хамгаалах эрхийн харилцаа сүрхий мөрдөгдөж ирсэн гэж үздэг юм байна.

IV. Монгол Улс газар нутгийн хаа аль хэсэгт ашигт малтмал олборлох хайх (зөвшөөрөх), аль хэсгийг нь бэлчээрт ашиглах, бэлчээрийн газрын тодорхойлолтыг нэгмөр цэгцлэх, тусгай хамгаалалт-тай газар нутгийн хэмжээг ямар хүрээ хязгаар дотор барих, хаана хот тосгоноо байгуулах босгох .. гэхчилэнгийн олон асуудал ул суурьтай цэгцлэгдээгүй байхад малын бэлчээр өмчлөл, бэлчээр эзэмшүүллийн тухай хууль гаргах нь [одоохондоо] эртэдсэн алхам болж мэдэхээр юм байна. Газар өмчлөх явц султай байна, энэ процесс гүнзгийрэг, ядаж газраа өмчилсөн иргэний тоо (монголд) хагас саяыг даваг ..

V. Бэлчээрийн мэдээ “олон саяар их тоогоор яригдаад .. уншигдаж өгөхгүй” байна. Энд, газрыг га –гаар хэмждэг; гэж зүтгэлгүй, хэмжээсийг “нүдэнд харагдуулах”-ын тулд” [км^2] -д шилжүүлж хэвшье. Бэлчээр бол “ногооны газар”, бүр “700-ийн пойл[97] тариан талбай” ч биш, харин, энгүй эд захгүй зай тул түүнд өөрт нь таарсан хэмжүүр хэрэгтэй байна. Жишээ нь, асфальтан замын гүйцэтгэлийг (уртааш км) –ээр яриад бишгүй болдог. Уг нь (газрын балансаа бодсон ч) урт өргөнтэй жинхэнэ талбай юм байгаам. Бэлчээрээ ч бид түүн лүгээ адил км –ээр харъя. Албан бус зарим мэдээнд, жишээ нь, монголыг 140 сая га. бэлчээртэй гэх. Улсын нутаг дэвсгэрийг 90% -тай тэнцэх тоо. Бараг ойтой газраа дангаар нь хасахад л ийм газар үлдэнэ. Тэгэхээр, хот суурин, уул уурхай, зам харгуй, газар тариалан, гол нуур, ян хэцээ яахав .. г. м.

[97] поле;

Газар зохион байгуулалтын Улсын ерөнхий төлөвлөгөө (Засгийн газрын 2003 оны 264 дүгээр тогтоолын хавсралт) -нд туссанаар, монголын нийт бэлчээрийн талбай – 112 сая га., үүнээс доройтсон бэлчээрийн хэмжээ - 22 сая га. Нийт бэлчээрийн ~10% нь үлийн цагаан оготнод идэгдсэн байдалтай байна.

Монгол Улсын газрын балансаар бэлчээрт тохиромжтой нийт нутгаас 15,9 сая га бэлчээрийг 4 ангиллаар (дархан цаазат, байгалийн цогцолборт, байгалийн нөөц, байгалийн дурсгалт) тусгай хамгаалалттай газар гэж үзэж .. нийтдээ ~125,7 сая га нутгийг “бэлчээрийн эдэлбэр нутаг”-т тооцдог байна.

Агаараас авсан энэ зураг дээр малын бэлчээр машин зам хоёр эзлэх талбайгаараа эн тэнцүүхэн “өрсөлдөж” байна.
Зарим газарт бэлчээрийг мал талхлаад байна уу машин тэрэг талхлаад байна уу гэдэг маргаантай асуудлын нэг ажээ.

VI. Монгол малчны аж төрөх уламжлалт арга барил өөрчлөгдсөнийг, “эртний нүүдэлчид” хагас суурин болсныг тооцохгүйгээр бэлчээрийн асуудлыг цагийн байдал тохируулан зохистой шийдэх боломжгүй юм. Бэлчээрийн хуулийн төсөлд явж байгаа “бэлчээрийн тодорхойлолт” тун ядуу харагдсан. Бэлчээрийн сэдэвт гүнзгийрэлгүй, эсхүл явцуу асуудлаар дагнасан, аж амьдралаас тасархай элдэв эргэлзээт тоо дүгнэлтээр шийдвэр гаргагчдыг будилуулах байдалд оруулдаг тал байх шиг байна.

1980 -аад онд улсын нийт бэлчээрийн 60% -г усжуулсан стат. үзүүлэлт байдаг. Тэр үед БНМАУ 25 сая малтай байлаа. Тэр малын тоо толгой эдүгээ бараг 2 дахин өсчихөөд байхад [хэмжээ нь тогтмол шахуу бэлчээрийн] усжуулалтын байдал эсрэгээрээ 40% -д очтол дорогш буужээ. Асуудал олон талтай, “бэлчээрийн асуудал” өөрөө “усны проблем” -ын хавсарга, түүний нэг таагүй илэрц болж харагдах шинжтэй. Үнэхээр, бэлчээр бол эхлээд ус .. дараа нь өвс юм байна. Энэ мэт эсрэгцсэн зураг жишээ олныг өгүүлж болохоор байдаг.

Бэлчээрийн талаарх эрхзүйн зохицуулалт “амаргүй даалгавар” бөгөөд үүнийг зохистой шийдэхэд малд нүдтэй бэлчээрт зөнтэй өвгөдийн үлдээсэн өв туршлага ямар нэг байдлаар “чигийг зааж” .. хэрэг болох нь дамжиггүй. Дээрээс шууд шийдэж болдоггүй асуудал гэж байдаг бол тэдгээрийн нэгд, [энэ] бэлчээрийн өмчлөл - эзэмшлийн асуудал лавтайяа орох биз ээ.

Энд тэмдэглэхгүй өнгөрч болохгүй өөр нэг зүйл бол хүн төрөлхтөнийг нийтлэг гамшиг болсон цөлжилт юм. Дэлхийн уур амьсгалын өөчлөлтийн сөрөг үр болсон энэхүү форс-мажор[98] үзэгдэл монголыг “бүхэлд нь залгиж” байгааг судалгаагаар нэгэнт тогтоожээ. Монголын өмнөд хэсэгт сарны гадарга шиг болчихсон газар орон их бий. Цөлжилтийн .. хойд зүгрүү тэмүүлж давшдаг дундаж хурд [.. км/жил] хүртэл тодорхойлогдсон юм. Бэлчээрийн хуулийн агуулгын хүрээнд дам байдлаар энэ асуудал заавал хөндөгдөх учиртай. Гэтэл мэргэжилтнүүд үүнийг орхигдуулаад тойроод байна. Цөлжилтийг бид мал амьдралтай холбохгүй [зүгээр л] тусад нь ярьдаг сэдэв болгочихсон мэт санагдав.

> Цөлжилт, газрын доройтолд өртсөн бүс нутаг хүрээгээ тэлсээр дэлхийн хуурай газрын 41% -г эзэлдэг болов. Цөлжилтөөс үүдсэн эдийн засгийн хохирол хүн төрөлхтөнд жилдээ 42 тэрбум ам. долл. –ын хохирол учруулдаг гэдэг. Манайд бэлчээр сүйтгэдэг гэх шалтгаанаар ямааг цөөлөх устгах үг яриа ч гардаг. Ямааг устгасны дараа бэлчээрийн байдал эрс сайжрах магадлал ямар байх бол?! Бэлчээр, цөлжилтийн асуудлын нэг аюул нь хаана бодитой, эсхүл хэн худал хуурмаг **хийсвэр зүйл** яриад байгаа нь ялгагддаггүйд оршино.

Сэдэвчилж түүвэрлэсэн чамлахааргүй хэмжээний холбогдох мэдээллийг харж байхад, орон нутаг талдаа бэлчээрийг “хуультай болгож авах замаар [түүгээрээ] бэлчээрийн маргааныг “цэгцэлж авах” давхар санаа агуулсан байж мэдмээр байдал анзаарагдсан. Ер нь, Үндсэн хуулийн холбогдох заалтыг түшиж, бэлчээр зохицуулалтын асуудал дээр “эрх бүхий субъект өөрийнхөө бүрэн эрхэд хадгалагдаж хамаардаг тодорхой эрх-мэдлийг орон нутагт [зоригтой] шилжүүлэх” боломжтойг өмнө бид дурдсан билээ.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- НҮБХХ -ийн “Бэлчээрийн тогтвортой менежмент” төсөл (2003 - 2004) -ийн хүрээнд бэлтгэгдсэн “Бэлчээрийн менежментийн бодлогын гарын авлага”, УБ., 2004;
- Т.Алтангэрэл, “XYI - XYII зууны Монгол цаазын бичгүүд”, УБ., 1999;
- О.Амархүү, “Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн түүхэн хөгжил, тогтвортой хөгжилд тэдгээрийн эзлэх байр суурийн асуудал”, УБ., 1999;
- Б.Баярсайхан, “Монгол цаазын бичиг”, УБ., 2001;
- Д.Лүндээжанцан, Ж.Болдбаатар, “Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал”, УБ., 1997;
- И.Дашням, “Монгол оронд дундад үеийн эрх зүйн тогтолцоог халж шинэ үеийн эрх зүйн анхны тогтолцоо бүрэлдэн тогтсон нь (1921 - 1940)”, УБ., 2002;
- С.Жалан-Аажав, “Халх журам бол Монголын хууль цаазны эртний дурсгалт бичиг мөн”, УБ., 1958;
- Др.Энх-Амгалан, “Бэлчээрийн асуудлыг ингэж шийдье” асуудал дэвшүүлсэн өгүүлэл, *“Зууны мэдээ”* сонин, 2007.12.18, №301;
- Бусад (Интернет мэдээллийн сангийн холбогдолт зарим ресурс);

[98][фр. force majeure] - бурхны гэсгээл, байгалийн давагдашгүй хүчин зүйл; гэсэн утгатай;